

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 43.040.01

Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага	MNS 4598 : 2011
General requirement for technical condition of road vehicles	MNS 4598 : 2003-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2012 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын үзүүлэлт, шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

1.1. Энэхүү стандартын зорилго нь автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих аюулгүйн шаардлага, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд нөлөөлөх техникийн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох, энэ талаар төрөөс тавих хяналтыг хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Энэ стандартын шаардлагыг бүрэн хангасан автотээврийн хэрэгсэлд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр замын хөдөлгөөнд оролцох гэрчилгээ олгоно.

2. Хамрах ба хэрэглэх хүрээ

2.1. Автотээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, энэ чиглэлээр хяналт тавих байгууллага, инженер техникийн ажилтан мөрдөж хэрэглэнэ.

2.2. Энэхүү стандартыг замын хөдөлгөөнд оролцох бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн техникийн байдлын хяналтын үзлэг, хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийхэд хэрэглэнэ.

2.3. Ашиглалтын үед автотээврийн хэрэгслийн техникийн байдлыг үнэлэх, шалгах аргыг тогтооход үндэс болно.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)–ийг хэрэглэнэ. Үүнд:

3.1. “Замын хөдөлгөөний тухай” Олон улсын венийн конвенци 1968.11.08

3.2. MNS ISO 3780 , Автотээврийн хэрэгслийн дэлхийн үйлдвэрлэгчийг таних тэмдгийн (WMI) код,

3.3. MNS ISO 3799, Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар (VIN) Агуулга ба бүтэц,

3.4. MNS ISO 3833 , Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэршил ба тодорхойлолт,

3.5. MNS 5013 , Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ,

MNS 4598 : 2011

- 3.6. MNS 4599 ,Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд,
- 3.7. MNS 4601, Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо, тодорхойлолт,
- 3.8. MNS 5014, Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ,
- 3.9. ISO 6597, Road vehicles with hydraulic braking systems with and without antilock device - Measurement of braking performance,
- 3.10. ISO 10604, Road vehicles - Measurement equipment for orientation of headlamp luminous beams,
- 3.11. ГОСТ Р 51709, Требования безопасности к техническому состоянию и методы проверки с изменением¹¹ утвержденным в августе 2005 г (ИУС 11-2005 г) поправкой (ИУС 9-2002г),
- 3.12. ГОСТ Р 52280, Автомобили грузовые. Общие технические требования.
- 3.13¹. COUNCIL DIRECTIVE. 96/53/EC of 25 July 1996. Laying down for certain road vehicles circulating within the Community the maximum authorized dimensions in national and international traffic and the maximum authorized weights in international traffic Үндэсний болон олон улсын замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн жишиг хамгийн их хэмжээ, жин, эргэлтийн радиусын талаар Европын холбооны 96/53 багц зөвлөмж
- 3.14² MNS ISO 4030 , Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар (VIN) – байрлал ба бэхэлгээ

3.15 MNS 6278:2011, Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага

4. Нэр томъёо, тодорхойлолт

4.1.

автотээврийн хэрэгсэл

зорчигч ба ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээврийн хэрэгсэл

4.2.

автоугсраа

нэг ба хэд хэдэн бие даасан чиргүүлийг холбосон бүрэлдэхүүн

4.3³

угсраа автобус

хатуу нугасаар холбогдсон, хоёр буюу түүнээс дээш хэсэг бүхий автобус. Энэ төрлийн автобусын аль ч хэсэгт зорчигч суугаа буюу зогсоогоор зорчин явах, хэсэг хоорондын хатуу нугасан холбоосоор дамжин чөлөөтэй шилжих боломжтой. Хоёр хэсгийг хооронд нь нэгтгэх, эсвэл хэсгүүдийг тусгаарлах ажлыг зөвхөн **үйлдвэрийн** нөхцөлд хийж, гүйцэтгэнэ.

4.4⁴

тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл

хийц ба тоноглолын хувьд дараах зориулалтаар ашиглах автотээврийн хэрэгсэл

-зөвхөн тусгай зориулалтын ажил, үүрэг гүйцэтгэх ба тусгай зориулалтын ачаа тээвэрлэх,

4.3.

тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл

хийц ба тоноглолын хувьд дараах зориулалтаар ашиглах автотээврийн хэрэгсэл

-зөвхөн тусгай зориулалтын ажил, үүрэг гүйцэтгэх ба тусгай зориулалтын ачаа тээвэрлэх,

-зөвхөн тусгай зориулалтын ажлын зорилгоор (жишээ нь холимог автотээврийн хэрэгсэл, суудлын автомашин, гал түймэр унтраах автомашин, хүн, мал эмнэлгийн түргэн тусламжийн автомашин, тусгай үйлчилгээний ачааны автомашин, хог тээврийн автомашин, хоёр зориулалтаар ашиглах автомашин, түр сууцны зориулалтаар ашиглах автомашин гэх мэтээр уг тээврийн хэрэгслийн зориулалтын хэлбэр янз бүр байна) Энэ автомашинд чиргүүл чирч болно.

4.4.

автотээврийн хэрэгслийн бүх жин

тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон өөрийн болон ачаа, жолооч, зорчигчийн нийт зөвшөөрөгдөх дээд жин. Чиргүүл нь тухайн тээврийн хэрэгслийн бүтцэд хамаарагдах бол бүх жинг чирэгч, чиргүүлийн бүх жингийн нийлбэрээр тооцно.

4.5.

автотээврийн хэрэгслийн бодит жин

тээврийн хэрэгслийн ашиглалтын тухайн үеийн жин. Чирэгдэж яваа тээврийн хэрэгслийн жинг бодит жинд оролцуулан тооцно.

4.6.

тэнхлэг дээрх ачаалал

нэг буюу хэд хэдэн тэнхлэгээс дугуйгаар дамжин замын гадаргууд үзүүлэх бодит ачаалал

4.7.

жолооны механизм

автомашинны хөдөлгөөнийг жолоочийн удирдлагаар хүч дамжуулан залах техникийн иж бүрдэл

4.8.

тоормосны систем

автомашинны хөдөлгөөний хурдыг жолоочийн удирдлагаар удаашруулах, зогсоох техникийн иж бүрдэл

4.9.

зогсоолын тоормос

жолоочгүй тээврийн хэрэгслийг буюу салгаж тавьсан чиргүүлийн хөдөлгөөнийг удаашруулах ба зогсооход зориулагдсан техникийн бүрдэл

4.10.

цахилгаан тоноглол

автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, зорчигчийн ая тухтай байдлыг хангах цахилгаан хэрэглүүрүүдийн техникийн иж бүрдэл

4.11.

чиргүүл

механикжсан тээврийн хэрэгслээр чирэхэд зориулсан тээврийн хэрэгсэл;

4.12.

хагас чиргүүл

зүтгүүрт холбон ашиглах зориулалттай нийт массынх нь үлэмж хэсэг нь холбоосоор дамжин зүтгүүр дээр ирэх, чиргүүл

4.13.

нам аралтай чиргүүл

жин, хэмжээ, тэнхлэгийн даацын хувьд ердийн чиргүүл, хагас чиргүүлээс том, онцгой хүнд жинтэй, овор ихтэй ачаа тээвэрлэхэд зориулагдсан ачааны автомашин, трактор, өөрөө явагч хэрэгсэлд холбосон чиргүүл, хагас чиргүүл

5. Нийтлэг шаардлага

5.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр автозамын хөдөлгөөнд оролцох бүх төрлийн автотээврийн хэрэгсэл нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн шаардлагыг бүрэн хангасан байна. Мөн “MNS 4597 Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” үндэсний стандартын шаардлагыг дагаж мөрдөнө.

5.2. Автотээврийн хэрэгсэл нь төрөл бүрийн ачаа, зорчигч тээвэрлэх нөхцөл, автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих нийтлэг болон улс ба хот хоорондын харилцаанд ачаа, зорчигч, жуулчин тээвэрлэх, тэрчлэн нийтийн үйлчилгээний автобус, таксийн техникийн байдалд тавих нэмэгдэл шаардлагуудыг бүрэн хангасан байна.

5.3. Эдэлгээний баталгаат гүйлт, гүйлтийн нөөц ихтэй, техникийн үйлчилгээний үечлэл урт, хөдөлмөр зарцуулалт, засвар бага шаардах, найдварт ажиллагааны түвшин өндөр байна. Автотээврийн хэрэгслийн эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишгийг үндэслэн автомашин бүхий аж ахуйн нэгж, байгууллага тухайн автотээврийн хэрэгслийн эдэлгээний нормыг тогтоож мөрдөнө. Автотээврийн хэрэгслийн техникийн оношлогоо үйлчилгээний хугацаа, үечлэл, хөдөлмөр зарцуулалтын нормативыг тогтооход “Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо, тодорхойлолт MNS 4601 : 2011” үндэсний стандартын шаардлагыг үндэслэл болгоно.

5.4. Техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар, өнгө үзэмж сайн, хэмнэлттэй, шатахуун, тосолгооны материал, ашиглалтын бусад материалаа бага зарцуулдаг, хүн ам, хүрээлэн буй орчинд аюулгүй, экологийн шаардлага хангасан байна.

5.5. Замын хөдөлгөөнд оролцох автотээврийн хэрэгсэл нь техникийн хувьд бүрэн бүтэн, техникийн үйлчилгээ, тохиргоог бүрэн хийсэн, техникийн хяналтын үзлэг оношлогоонд орж, шаардлага хангасан, замын хөдөлгөөнд оролцох эрхийн гэрчилгээ авсан байна.

5.6. Автотээврийн хэрэгслийн улсын дугаар, таних болон ялгах тэмдэг, бичлэгүүд хүчин төгөлдөр мөрдөж буй стандартын үзүүлэлт, техникийн шаардлагыг хангасан, чанартай хийж тавигдсан байна.

5.7. Автотээврийн хэрэгслийн тэвш, бүхээг, чингэлэг, гишгүүр, шат, бариул, суудал, түшлэг нь тээвэрлэлтийн нехцөл, стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

5.8. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр улс хоорондын болон дотоодын харилцаанд тээврийн үүрэг гүйцэтгэх автотээврийн хэрэгслийн жин 1-р хүснэгт, оврын зөвшөөрөгдөх дээд хэмжээ 2-р хүснэгтэд заасан хэмжээнд байна. Үүнд:

5.8.1. Автотээврийн хэрэгслийн бүх жин ба уртын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

5.8.1.1. Автотээврийн хэрэгслийн бүх жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь:

1-р хүснэгт - Автотээврийн хэрэгслийн бүх жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Тээврийн хэрэгслийн төрөл, тэнхлэгийн тоо	Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх хамгийн их жин
Дан тээврийн хэрэгсэл	
Хоёр тэнхлэгтэй	18 тонн
Гурван тэнхлэгтэй	25 тонн
Дөрвөн тэнхлэгтэй	32 тонн
Тав болон түүнээс олон тэнхлэгтэй	38 тонн
Угсраа автобус	28 тонн
Эмээлт автоугсраа болон чиргүүлтэй тээврийн хэрэгсэл	
Гурван тэнхлэгтэй	28 тонн
Дөрвөн тэнхлэгтэй	36 тонн
Таван тэнхлэгтэй	40 тонн
Зургаа болон түүнээс олон тэнхлэгтэй	44 тонн
Чиргүүл	
Хоёр тэнхлэгтэй	18 тонн
Гурван тэнхлэгтэй	24 тонн








5.8.1.2. Автотээврийн хэрэгслийн **оворын** зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь:


2-р хүснэгт - Автотээврийн хэрэгслийн **оворын** зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Тээврийн хэрэгслийн овор		Хэмжээ
Урт	Чиргүүлгүй дан тээврийн хэрэгсэл	12 метр
	Чиргүүл	12 метр
	Авто угсраа	20 метр
	Угсраа автобус	18,75 метр
Өргөн	Бүх төрлийн тээврийн хэрэгсэл	2,55 метр
	Хөргүүртэй тээврийн хэрэгсэл	2,60 метр
Өндөр	Бүр төрлийн тээврийн	4 метр

5.8.1.3. Автотээврийн хэрэгслийн тэнхлэг дээрх зөвшөөрөгдөх хамгийн их ачаалал:

2-р хүснэгт - Автотээврийн хэрэгслийн тэнхлэг дээрх зөвшөөрөгдөх хамгийн их ачаалал

Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн дугуйн төрөл	Тэнхлэгийн төрөл	Тэнхлэгийн хоорондын зам, м	Тэнхлэг дээрх хамгийн их ачаалал, тн	
Дан дугуйтай тэнхлэг	 Нэг тэнхлэг	2,5 м-ээс их	10.5 тн/тэнхлэг	
	 Хос тэнхлэг	1 м хүртэл	11.5 тн/бүлэг тэнхлэг	
		1 м-ээс 1.3 м хүртэл	14 тн/бүлэг тэнхлэг	
		1.3 м-ээс 1.8 м хүртэл	17 тн/бүлэг тэнхлэг	
	 Гурвалсан тэнхлэг	1.8 м-ээс 2.5 м хүртэл	18 тн/бүлэг тэнхлэг	
		1 м хүртэл	17 тн/бүлэг тэнхлэг	
		1 м-ээс 1.3 м хүртэл	20 тн/бүлэг тэнхлэг	
	 Дөрөв болон түүнээс олон тэнхлэг	1.3 м-ээс 1.8 м хүртэл	23.5 тн/бүлэг тэнхлэг	
		1.8 м-ээс 2.5 м хүртэл	25 тн/бүлэг тэнхлэг	
		1 м хүртэл	5.5 тн/тэнхлэг	
		1 м-ээс 1.3 м хүртэл	6.5 тн/тэнхлэг	
	Давхар дугуйтай тэнхлэг	 Нэг тэнхлэг	2,5 м-ээс их	11.5 тн/тэнхлэг
		 Хос тэнхлэг	1 м хүртэл	12.5 тн/бүлэг тэнхлэг
			1 м-ээс 1.3 м хүртэл	16 тн/бүлэг тэнхлэг
1.3 м-ээс 1.8 м хүртэл			18 тн/бүлэг тэнхлэг	
1.8 м-ээс 2.5 м хүртэл			20 тн/бүлэг тэнхлэг	
 Гурвалсан тэнхлэг		1 м хүртэл	18 тн/бүлэг тэнхлэг	
		1 м-ээс 1.3 м хүртэл	21 тн/бүлэг тэнхлэг	
		1.3 м-ээс 1.8 м хүртэл	24 тн/бүлэг тэнхлэг	
		1.8 м-ээс 2.5 м хүртэл	26 тн/бүлэг тэнхлэг	

 <p>дөрөв болон түүнээс олон тэнхлэг</p>	1 м хүртэл	6 тн/тэнхлэг
	1 м-ээс 1.3 м хүртэл	7 тн/тэнхлэг
	1.3 м-ээс 1.8 м хүртэл	8 тн/тэнхлэг
	1.8 м-ээс 2.5 м хүртэл	9 тн/тэнхлэг

/АТБХЗГ-Европын холбооны зөвлөлийн 1996.07.25-ны №96/53/ЕС удирдамж (Европын холбооны нутаг дэвсгэрт тээвэрлэлт гүйцэтгэж буй автомашины зөвшөөрөгдөх хамгийн их оворын ба жингийн хэмжээг тогтоосон)/

5.8.2. Нэг хөтлөгч тэнхлэг дээрх хамгийн их ачаалал 11,5 т, хөтлөгдөх тэнхлэг дээрх хамгийн их ачаалал 10 т-оос тус тус ихгүй байна. Аль нэг тэнхлэг дээрх хамгийн их ачаалал нь бүх жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээний хүрээнд хувиарилагдаж тооцогдоно.

⁵ СҮЗ-ийн 2012 оны 20 дугаар тогтоолын дагуу нэмэлт өөрчлөлт оруулав.

⁶ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.

⁷ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.

5.8.3. ⁸Автотээврийн хэрэгслийн өргөний хязгаар 2,5 м, (угсраа автобус хязгаар 2,55 м) ачаалласан өндөр 4 м-ээс ихгүй байна.⁹

5.8.4. Харин хөдөө аж ахуйн (ургац хураах, цайруулах машин г.м.) болон зам барилгын (их даацын өөрөө буулгах ба хусах автомашин) ажилд зориулагдсан зарим өөрөө явагч хэрэгслийн өргөний зөвшөөрөгдөх дээд хязгаар 3,3 м-ээс илүүгүй байна.

Зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү гарах тохиолдолд холбогдох байгууллагуудаас тусгай зөвшөөрөл авна.

5.8.5⁹ Тусгай зориулалтын автозамын тээвэрлэлтэд ашиглах хүнд даацын автотээврийн хэрэгсэлд тавигдах техникийн ерөнхий шаардлагыг тусад нь стандартаар тодорхойлно.

5.9. Хүн ам, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх хөдөлгүүр агрегат, зангилаа, механизмуудын техникийн үзүүлэлтүүд нь “Бензин хөдөлгүүртэй автомашин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS 5013, “Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS 5014, “Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд” MNS 4599 зэрэг үндэсний стандартаар тогтоосон зөвшөөрөгдөх норм, хүлцэх хэмжээний шаардлагыг хангасан байна.

5.10. Хүч дамжуулах анги

5.10.1. Хүч дамжуулах ангийн агрегат, зангилаа, эд ангиуд нь техникийн хувьд бүрэн, иж бүрдэлтэй, холбоосуудын бэхэлгээ найдвартай, кардан гол савлагаагүй, ерөнхий дамжуулга нь хэвийн ажиллагаатай байна.

5.10.2. Дискэн холбоо нь нэг удаагийн даралтаар алгуур салж, залгагдаж, хий эргэдэггүй байхын зэрэгцээ дөрөөний сул явалтын зай нь 20 мм-ээс 45 мм, дискэн холбоог салгах хүч нь 15 кг-аас тус тус ихгүй байна.

5.10.3. Хурдны хайрцгийн дамжуулгын залгах хүч 6 кг-аас ихгүй, дамжуулгууд нь алгуур залгагддаг, ажиллагааны үед дуу чимээгүй, эсвэл дуу чимээ маш бага байх шаардлагатай.

5.11. Жолооны механизм

5.11.1. Автотээврийн хэрэгслийн жолооны хүрдний сул эргэлт нь 3-р хүснэгтэд заасан хэмжээнээс ихгүй, эргүүлэхэд зөөлөн байна.

3-р хүснэгт

№	Автомашин төрөл	Жолооны хүрдний сул эргэлт, градус	
1	Суудлын автомашин	5	
2	Автобус	10	
3	Ачааны автомашин	Жолооны удирдлагын шингэн хүчлүүртэй	Жолооны удирдлагын шингэн хүчлүүргүй
		10	5

⁸ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.

⁹ СҮЗ-ийн 2012 оны 20 дугаар тогтоолын дагуу нэмэлт өөрчлөлт оруулав.

5.11.2. Жолооны хүрдний зөвшөөрөгдөх сул эргэлт нь жолооны механизмын бүрдэл хэсгүүдэд жигд хуваарилагдсан байна.

5.12. Тоормосны систем

5.12.1. Автотээврийн хэрэгслийн ажлын болон зогсоолын тоормосны ажиллагаа нь найдвартай, хөдөлгөөний удаашралтын хамгийн бага хэмжээ 4-р хүснэгтэд заасан хэмжээнээс ихгүй байна.

4-р хүснэгт

№	Автомашин төрөл	Тоормослох үеийн хөдөлгөөний удаашралтын хамгийн доод хэмжээ, м/сек ²		
1	Суудлын автомашин	5,2		
2	Автобус	Бага багтаамжийн	Дунд, их багтаамжийн	
		5,2	4,5	
3	Ачааны автомашин	Бүх жин нь 3,5 т хүртэлх	3,5 т-оос 12 т	12 т-оос дээш
		5,7	5,7	6,2

5.13. Цахилгаан тоноглол

5.13.1. Гэрэлтүүлэг дохиоллын хэрэгслүүдээр, тухайлбал гэрлийн шил, чийдэн, ойлгогч г.м. иж бүрдэл, бүрэн тоноглогдсон, тэдгээр нь олон улс болон үндэсний стандартын шаардлага хангасан байна.

5.13.2. Хурд хэмжүүр нь баталгаажуулагдсан байх бөгөөд дуут дохио бүрэн ажиллагаатай байна.

5.13.3. Гэрлийн өнгө:

- урд гэрэл: цагаан
- манангийн гэрэл: шар
- хойд гэрэл: улаан
- хажуугийн гэрэл: шар
- зогсоолын гэрэл: улаан
- дохионы гэрэл: улбар шар, улаан
- ухрах хөдөлгөөний гэрэл: цагаан байна.

5.13.4. Замын хөдөлгөөнд оролцогчдод таагүй байдал үүсэхээс сэргийлж зүүн гар талын хөдөлгөөнд нийцсэн гэрлийн тусгалыг баруун гар талын хөдөлгөөнд нийцсэн гэрлийн тусгалтай болгож өөрчилж болно. Энэ тохиолдолд ойрын гэрлийн хүч 0.86D-1.72R цэгт 2500 кд-аас их, 0.57U-3.43L цэгт 880 кд-аас бага байна.¹⁰

ТАЙЛБАР : Гэрлийн тусгалыг өөрчлөхдөө 1958 онд Женев хотод батлагдсан хэлэлцээрийн хүрээнд, НҮБ-ээс гаргадаг техникийн R112 дугаар зохицуулалтын 5.8.1 болон 5.8.2.2-т заалт, гэрлийн тусгалыг хэмжихдээ техникийн R48 дугаар зохицуулалтыг баримтална.

¹⁰ СҮЗ-ийн 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон.

5.14. Явах анги

5.14.1. Явах ангийн үндсэн зангилаа, эд ангиуд нь техникийн хувьд бүрэн, холбоосуудын бэхэлгээ найдвартай, тохиргоо бүрэн хийгдсэн, урд тэнхлэг, арал, их бие, нум, зөөлрүүл, зөөлөвч резинүүдийн бэхэлгээ сайн, дуу чимээгүй, ачааны үндсэн ба туслах арлын эд анги, тулгуурууд техникийн хувьд бүрэн, иж бүрдэлтэй байна.

5.14.2 Дугуйн хийн даралтын байвал зохих хэмжээг үйлдвэрлэгч тухайн автомашины хийц загвар, бүтцээс хамааруулан тодорхойлно.

5.14.3. Дугуйн хээний гүн нь газарт тулах хэсгээрээ 5-р хүснэгтэд заасан хэмжээнээс багагүй байх бөгөөд дугуйны элэгдлийн тэмдэглэгээний хязгаар хүрсэн тохиолдолд ашиглахыг хориглоно.

5- р хүснэгт - Дугуйн хээний гүний хэмжээ

№	Автомашин төрөл	Хээний гүн, мм-ээр
1	Суудлын автомашин	1,6
2	Автобус	2.0
3	Ачааны автомашин	1.0

5.15¹⁰ Бусад нэмэгдэл төхөөрөмж, хэрэгслүүд

5.15.1 Жолоочийн ажиллах, зорчигчдын аятай тавлаг зорчих нөхцөлийг бүрэн хангахын тулд дараах нэмэгдэл хэрэгсэл, төхөөрөмжүүдээр тоноглогдсон байх шаардлагатай. Үүнд:

- нарны хаалт
- гал унтраагуур
- жолоочийн иж бүрэн багаж хэрэгсэл
- автомашины өргүүр (домкрат)
- нөөц дугуй (1 ширхэг)
- эмийн сан
- ослын зогсолтын тэмдэг

5.15.2 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлийн хяналт, бүртгэлийг сайжруулах үүднээс тээврийн хэрэгслийг хяналтын камераар тоноглож болно.

6 Суудлын автомашинд тавих техникийн нэмэгдэл шаардлага

6.1 Суудлын автомашины кузов

6.1.1 Суудлын автомашины кузов нь өнгө үзэмж, битүүмжлэл сайн, гадна орчноос тоос шороо, дуу чимээ, ус нэвтрэхгүй байх, салхины болон хажуугийн, арын шилнүүд, шал, хаалга, капот, тээшний түгжээ бүрэн, эвдрэл гэмтэлгүй байна. Суудал, түшлэг нь тавлаг зөөлөн, жолоочийн биеийн жин, өндрөөс хамааруулж тохируулах боломжтой, жолооч зорчигчдын бие хөлрөх, чийг татах явдал гаргахгүй эрүүл ахуйн шаардлага хангах /тусгай хассан/ материалаар бүрсэн байна.

6.1.2 Урд ба арын суудалдаа заавал үйлдвэрлэгчийн тавьсан аюулгүйн бүс,

MNS 4598 : 2011

дэртэй байна. Мөн аюулгүйн бүс нь бүрэн ажиллагаатай байх ёстой.

6.2 Тоормосны систем

6.2.1 Суудлын автомашины хөдөлгөөний удаашралт 8 м/сек^2 хүртэл явагдах үед урд дугуйнууд хойд дугуйнуудаас урьтаж тоормослоно.

6.2.2 Суудлын автомашины зогсоолын тоормос нь 23.0 хувийн налууд уг автомашиныг хөдөлгөөнгүй барьж байх шаардлагатай.

6.3 Цахилгаан тоноглол

Стандарт, хэмжил зүйн газар.

6.3.1 ¹¹Урд гэрлийн тохиргоо алдагдаагүй хэвийн байна. Ойрын болон холын гэрлийн тусгалын хязгаар нь доод тал нь 1 %-ийн (10 мм/м) хазайлттай байхаар тохируулна. Гэрлийн тусгалын чадлын хэмжээ 10.000 cd –ээс 225.000 cd байна.

6.4 Бусад нэмэгдэл төхөөрөмж, хэрэгсэл

6.4.1 Жолоочийн ажиллах, зорчигчдын аятай тавлаг зорчих нөхцлийг бүрэн хангахын тулд дараах нэмэгдэл хэрэгсэл, төхөөрөмжүүдээр тоноглогдсон байх шаардлагатай. Үүнд:

- нарны хаалт
- гал унтраагуур
- жолоочийн иж бүрэн багаж хэрэгсэл
- автомашины өргүүр (домкрат)
- нөөц дугуй (1 ширхэг)
- дугуйн ивүүр (2 ширхэг)
- эмийн сан
- ослын зогсолтын тэмдэг

7 Нийтийн үйлчилгээний таксинд тавих техникийн нэмэгдэл шаардлага

7.1 Нийтийн үйлчилгээний такси нь энэхүү стандартын 5, 6-р зүйлд заасан шаардлага, Нийтийн таксийн үйлчилгээний MNS 5122 стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

8 Нийтийн үйлчилгээний автобуст тавих техникийн нэмэгдэл шаардлага

8.1 Автобусны кузов

Өнгө үзэмж, битүүмжлэл сайн, гадна орчноос ус чийг, тоос шороо нэвтрэхгүй, мөн жолоочийн бүхээг нь зорчигчдын танхимаас тусгаарласан байна.

8.1.1 ¹²Хотын доторх нийтийн үйлчилгээний автобус нь 2-оос дээш хаалгатай, багтаамж нь зорчигчдын суудал цөөн, зогсоогоор явах зорчигчдын тоо илүүтэй, орох, гарах хаалганы орчимд болон эгнээ хоорондын зай өргөн байна. Улс хоорондын, хот хоорондын, хот орчмын харилцаанд ажиллах автобус нь 1-ээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар олон суудал, гар тээшний тавиураар тоноглогдсон, тээш хадгалах хонгил байна.

8.1.2 Автобусны бариулын өндөр шалнаас дээш 1800 мм-ээс ихгүй, хүүхэд болон намхан нуруутай зорчигчдод зориулсан намсгасан нэмэлт бариултай, орох гарах хаалганы шатны гишгүүрийн өндөр 300 мм-ээс ихгүй байна.

8.1.3 Зорчигчдын танхим нь эрүүл ахуй, ариун цэвэр, галын болон хөдөлгөөний аюулгүйн шаардлагыг бүрэн хангасан, дулаацуулга, агааржуулалт, салхижуулалтын систем, ослын нэмэгдэл хаалга, цонх, нээлхий, гал унтраагуур, эмийн сан зэргээр тоноглогдсон байна.

8.1.4 Улс болон хот хоорондын харилцаанд ажиллах автобус нь хяналтын төхөөрөмж буюу тахограф суурилагдсан, зөөлөн суудал, түшлэгтэй, тэдгээр нь жолооч зорчигчдын биеийн жин, өндрөөс хамааруулан тохируулах боломжтой, бие хөлрөх, чийг татахгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан материалаар бүрсэн байна.

¹¹ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.

¹² Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.

8.1.5 Бүх төрлийн автобусны салхины болон хажуугийн, арын шилнүүд, хаалга, шил, зорчигчдын ачаа тээшний хонгилын түгжээ бүрэн, сандал түшлэг эвдрэл гэмтэлгүй, оврын гэрэл цацруулагчтай байна.

8.2 Тоормосны систем

8.2.1 Автобусны зогсоолын тоормос нь 23.0 хувийн налууд уг автомашиныг хөдөлгөөнгүй барьж байх шаардлагатай.

8.3 Цахилгаан тоноглол

8.3.1 Автобусны гадна дотор талын болон оврын, мөн маршрут заах, таних тэмдгийн, гишгүүр, хаалга, суудал орчны гэрэлтүүлэг бүрэн, тэдгээр нь олон улсын стандартын шаардлага хангасан байна. Бүх багтаамжийн автобус нь тоормосны системд гэмтэл гарсан үед мэдээлэх дохиоллын системтэй байна.

Бүх багтаамжийн автобусны хөдөлгүүр, хоромхон зуур унтраах аваарын болон аккумулятор салгагч зэргээр тоноглогдсон, тэдгээрийн удирдлага нь жолоочийн суудлын дэргэд ойрхон байрласан байх шаардлагатай.

8.4 Бусад нэмэгдэл төхөөрөмж, хэрэгслүүд

8.4.1 Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээний их багтаамжийн автобус нь нэгдсэн бүртгэлийн системд холбогдох станц, байршил тогтоогч, зорчигчдод мэдээлэл өгөх чанга яригч, буудал зарлах зэрэг төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

8.4.2¹³ Нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд жолоочийг зорчигчдоос тусгаарласан хагас буюу битүү бүхээгтэй байхаас гадна жолоочийн баруун гар талын хэсэгт тусгай тоноглол /хяналтын болон карт уншигч/ төхөөрөмж суурилуулах боломжоор хангагдах, бүхээг нь аваар ослын үед аюулгүй байдлыг хангасан байна.

8.4.3 Хот хоорондын болон улс хоорондын харилцааны тээвэрт ажиллах автобус нь жолоочийн ажиллах, зорчигчийн тавлаг нөхцөлийг бүрэн хангахын тулд дараах нэмэгдэл хэрэгсэл, төхөөрөмжүүдээр тоноглогдсон байна. Үүнд:

- чанга яригч, радио, магнитофон
- мэдээлэл, хяналтын төхөөрөмж (тахограф, GPS.....гэх мэт)
- эмийн сан
- гал унтраагуур
- цонхны хөшиг /зорчигчдын талын цонхны хөшиг нь нэг өнгийн байх/
- гар тээш тавих байр
- автомашины өргүүр
- жолоочийн иж бүрэн багаж
- нөөц дугуй /1-2 ширхэг/
- зорчигчдын ачаа тээшний хонгил /сав/
- дугуйн ивүүр /4ширхэг/
- ослын зогсолтын тэмдэг

¹³ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.

9 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэлд тавих техникийн нэмэгдэл шаардлага

Цахилгаан тээврийн хэрэгсэл нь энэхүү стандартын 5 дугаар зүйлийн нэмэгдэл шаардлага, “Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800F загварын Дуобус. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6225 : 2010 үндэсний стандартын шаардлагууд, мөн “Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800 загварын троллейбус угсрах, ашиглах. Үндсэн параметр ба техникийн ерөнхий шаардлага” MNS 5773 : 2007 үндэсний стандартын 7, 8 дугаар зүйлийн шаардлагыг бүрэн хангасан байна.

10 Ачаа тээврийн автомашинд тавих техникийн нэмэгдэл шаардлага

10.1 Ачааг тээвэрлэх явцад түүнийг бүрэн бүтэн, гэмтэлгүй хүргэх болон бороо, цас, тоос, шороо зэрэг байгалийн бусад нөлөөллөөс хамгаалахаар сайтар битүүмжлэгдсэн, түргэн муудаж гэмтдэг хүнсний зүйлийг тээхэд илч тусгаарлагч битүү тэвштэй эсвэл хөргөгч бүхий /рефрижератор/ битүү бүрхүүлтэй, овор ихтэй, хүнд урт ачааг тээвэрлэхэд найдвартай бэхэлгээгээр хангасан байна.

Мөн тусгай зориулалтын автотээврийн хэрэгслийн төрөлжсөн бүхээг, тэвш, механизм, нэмэгдэл тоноглолууд техникийн хувьд бүрэн, хөдөлгөөний болон аюулгүй үйл ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байна.

Чиргүүлтэй ажиллах автомашины чиргүүл, их даацын хагас чиргүүлийн тоормосны систем, гэрэл дохиоллын хэрэгслүүд бүрэн, чиргүүлийн гар, чирэгч хэрэгсэл, холбогч эмээл зэрэг хэрэгслэлүүд техникийн хувьд бүрэн, найдвартай ажиллагаатай байна.

10.2 Улс хоорондын болон хот хоорондын тээвэрлэлтийн зориулалтын тээврийн ачааны автомашинууд нь мэдээлэл, хяналтын төхөөрөмжүүдийг (тахограф GPS...гм) суурилуулсан байна. Бусад автомашинуудад тахограф суурилуулах зай байна.

10.3 Тоормосны систем

10.3.1 Ачааны автомашины тоормосны дөрөөн дээр үйлчлэх хүч нь 30 кг-аас ихгүй, зогсоолын тоормос нь 16 %-ийн налууд бүрэн ачаатай автомашиныг хөдөлгөөнгүй барьж байх шаардлагатай. Зүтгүүр автомашины чиргүүл, хагас чирүүлийн тоормос нь бүрэн ажиллагаатай, бүх дугуйндаа зэрэг барьж байх шаардлагатай.

10.3.2 Чиргүүл нь зүтгүүр автомашиныг татах буюу мөргөхөөс зайлсхийх зорилгоор зүтгүүр автомашин ба чиргүүлийн тоормосны идэвхжил тохирч байх шаардлагатай.

10.4 Цахилгаан тоноглол

10.4.1 Гэрэлтүүлэг, дохиоллын хэрэгслүүдээр, тухайлбал гэрлийн шил, чийдэн, ойлгогч г.м. иж бүрдэл, бүрэн тоноглогдсон, гэрэлтүүлэг нь тод байхын зэрэгцээ, чиргүүлтэй ажиллах автомашин, оврын гэрэл, бүхээг дээрх гэрэл дохио, манангийн гэрлээр бүрэн тоноглогдсон байна.

10.4.2 Урд гэрлийн тохиргоо алдагдаагүй хэвийн байна. Ойрын гэрлийг тусгалын хязгаар нь доод тал нь 1 %-ийн (10 мм/м) хазайлттай байхаар тохируулна. Гэрлийн чадлын хэмжээ 10.000 cd –ээс 225.000 cd байна.

10.5 Жолоочийн бүхээг

Жолоочийн бүхээгний салхины, мөн хажуугийн ба арын шил нь аюулгүйн зориулалтын бөгөөд гэмтэлгүй, бүрэн, хаалга, гишгүүр, капот нь сөхөгддөг, бүхээгний нугасан холбоосны бэхэлгээ, түгжээ найдвартай ажиллагаатай байна. Мөн жолоочийн суудал, түшлэг зөөлөн, жолоочийн биеийн жин, өндрөөс хамааруулж тохируулах боломжтой, удаан суухад бие тавгүйтэх, хөлрөх, чийг татахгүй эрүүл ахуйн шаардлага хангасан материалаар бүрсэн байна.

10.6 Кузов

Туслах арал, хөндлөн ба дагуу гуяны тулгуурын бэхэлгээ найдвартай, автомашины тэвшний шал, аравч хашлагууд зай завсаргүй, бүрэн түгжигддэг, битүү бүрхүүл бүхий кузов нь битүүмжлэл сайтай, лацдаж ломбодох нөхцөлийг хангасан байна.

10.7 Бусад нэмэгдэл төхөөрөмж, хэрэгслүүд

чаа тээврийн автомашин нь дараах нэмэгдэл төхөөрөмж, хэрэгслүүдээр тоноглогдсон байх шаардлагатай. Үүнд:

- эмийн сан
- нарны хаалт
- магнитол /радио, магнитофон/
- гал унтраагуур /2 ширхэг/
- паяльник*
- жолоочийн иж бүрэн багаж
- нөөц дугуй /1-2 ширхэг/
- автомашины өргүүр, домкрат
- дугуйн ивүүр /4 ширхэг/
- чирэх тросс
- тент /тэвшний битүү бүрхүүл/
- бүтээлэг, татлага
- ослын зогсолтын тэмдэг

11 Тусгай зориулалтын автотээврийн хэрэгсэлд тавих техникийн нэмэгдэл шаардлага

11.1 Тусгай зориулалтын автотээврийн хэрэгсэл нь энэхүү стандартын 5 дугаар заалт, мөн 6, 8, 10 дугаар заалтуудад хамрагдах ангиллын автотээврийн хэрэгсэлд тавих нийтлэг болон нэмэгдэл шаардлагыг бүрэн хангасан байна.

11.2 Тусгай зориулалтын бүхээг, тэвш, нэмэгдэл тоног төхөөрөмж нь тухайн ачааны тээвэрлэлтийн нөхцөл, шаардлагыг хангасан байна.

11.3 Тусгай зориулалтын автотээврийн хэрэгслийн нэмэгдэл тоног төхөөрөмж нь ашиглалт, хөдөлгөөний явцад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон

эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг тогтоосон стандарт, дүрэм, журмыг хангасан байна.

12 Чиргүүл, хагас чиргүүлд тавих техникийн нэмэгдэл шаардлага

12.1 Хоёроос дээш чиргүүл хэрэглэхийг хориглоно. Хагас чиргүүлийн араас чиргүүл залгахыг хориглоно.

12.2 Чиргүүлийн зөвшөөрөгдөх дээд жин болон хагас чиргүүлийн тэнхлэгт ноогдох ачааны зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх нийт жингээс 1,5 дахинаас ихгүй байна. Суудлын автомашинд залгасан чиргүүлийн нийт жин тухайн тээврийн хэрэгслийн ачаагүй жингээс ихгүй байна.

12.3 Чиргүүл буюу хагас чиргүүлийн зөвшөөрөгдөх өргөн нь тээврийн хэрэгслийн хоёр хажуу тал руу 10 см-ээс илүү гарахгүй байна.

12.4 Холбоос

12.4.1 Чиргүүл, хагас чиргүүл тохирсон холбоостой байна. Чигээрээ яваа нөхцөлд тээврийн хэрэгслийн болон чиргүүл, хагас чиргүүлийн дугуйнуудын хоорондын зай тогтмол байх ба нум зэрэг эд ангиуд өөрчлөлттэй байж болно.

12.4.2 Чиргүүл, хагас чиргүүлийн холбоосны эд ангиуд чирэгч тээврийн хэрэгсэлтэйгээ уялдан уян хатан холбогдсон байхаар байрласан байна.

12.5 Тоормос

12.5.1 Чиргүүл, хагас чиргүүл бүрэн ажиллагаатай, тоормосны нэг системтэй байна. 750 кг-ийн зөвшөөрөгдөх дээд жин бүхий чиргүүлийн хувьд энэхүү хэмжээ нь чирэгч хэрэгслийн нийт жингийн 50 %-иас хэтэрсэн тохиолдолд тоормосны систем шаардлагатай.

12.5.2 Чиргүүл, хагас чиргүүл нь чирэгч тээврийн хэрэгслээс салгагдсан тохиолдолд тоормосыг идэвхжүүлэх боломжтой байна.

12.5.3 Тоормосны хувьд чирэгч тээврийн хэрэгсэл ба чиргүүл, хагас чиргүүлийн холбоос эвдэрсэн тохиолдолд чиргүүл, хагас чиргүүл автоматаар тоормослохоор байна.

12.5.4 Чиргүүлийн тоормосны идэвхжил нь зүтгүүр автомашиныг татах, эсвэл түлхэхээс зайлсхийх үүднээс зүтгүүрийнхээ тоормосны идэвхжилтэй нийцэж байх ёстой.

12.6 Цахилгаан тоноглол

12.6.1 Чиргүүл, хагас чиргүүл нь урд талаасаа гэрэлтүүлэх болон дохиоллын хэрэгслээр тоноглогдсон байна.

12.6.2 Чиргүүл, хагас чиргүүлийг гэрэлтүүлэггүй нийтийн хэрэгцээний зам дээр тавихдаа урд талд нь цагаан, хойд талд нь улаан өнгийн гэрэл асаасан байна.

12.7 Арал

Чиргүүл, хагас чиргүүлийн аралд ачааны автомашинтай адил шаардлага тавина.

12.8 Их бие

Чиргүүл, хагас чиргүүлийн их биёд ачааны автомашинтай адил шаардлага тавина.

13 Мотоциклд тавих техникийн шаардлага

13.1 Жолооны механизм

Жолооны механизм баруун ба зүүн гар тийш 25 градус эргэх ба жолоочид аль ч чиглэлд гараа тавих зай хангалттай байх ёстой. Гар нь жолоочийн суудлаас дээш 300 мм-ээс илүүгүй өндөртэй, гар хоорондын зай нь 550 мм-ээс их байна.

13.2 Тоормос

13.2.1 Мотоцикл хоёр тусдаа удирдлага бүхий ажлын тоормостой байх ба эдгээр нь доод тал нь холбогдсон дугуйндаа үйлчилж байна. Тоормосны идэвхжил 50 %-иас доошгүй байна.

13.2.2 Тоормосны удаашралт нь хоёр дугуйтай мотоциклд 5,5 м/сек², шаахайтай мотоциклд 5 м/сек² байна.

13.3 Цахилгаан тоноглол

Мотоцикл нь холын гэрэл, ойрын гэрэл, оврын урд гэрэл, оврын хойд гэрэл, дугаарын гэрэл, арын ойлгогч улаан гэрэл, зогсолтын гэрэл тус бүр нэг ба дуут дохиотой байна. Мотоциклын шаахай оврын урд ба хойд гэрэл тус бүр нэгтэй байна.

13.4 Явах анги

Дугуйн хээний гүн 0,8 мм-ээс багагүй байна.

14 Нам аралтай чиргүүлд тавих шаардлага

14.1 Ачаа бүхий нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн зөвшөөрөгдөх дээд хурд дараах нөхцөлд 60 км/ц байна. Үүнд:

- тэнхлэгийн даац 10 т-оос хэтрэхгүй байх,
- автоугсрааны зөвшөөрөгдөх бүх жин 115 т-оос хэтрэхгүй нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн тоормосны идэвхжил доод тал нь 45 % байх,
- тэнхлэг бүр нумтай байх,
- тэнхлэгт ноогдох ачаалал 10 т-оос хэтэрвэл хийн нумтай байх.

14.2 Ачаа бүхий нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн зөвшөөрөгдөх дээд хурд дараах нөхцөлд 45 км/цаг байна. Үүнд:

- Автоугсрааны аль ч тэнхлэгт ноогдох ачаалал нэг дугуй нь өргөгдсөн тохиолдолд 10 т-оос, 2 дугуй нь өргөгдсөн тохиолдолд 12 т-оос хэтрэхгүй байх,
- автоугсрааны зөвшөөрөгдөх бүх жин 115 т-оос хэтрэхгүй байх,

- нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн тоормосны идэвхжил доод тал нь 45 % байх,
- тэнхлэг бүр нумтай байх,
- нэг болон хэд хэдэн тэнхлэгт ноогдох ачаалал 10 т-оос хэтэрвэл хийн нумтай байх.

14.3 Ачаа бүхий нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн зөвшөөрөгдөх дээд хурд дараах нөхцөлд 30 км/цаг байна. Үүнд:

- тээврийн хэрэгслийн цувааны аль ч тэнхлэгийн ачаалал нэг дугуй нь өргөгдсөн тохиолдолд 10 т-оос, 2 дугуй нь өргөгдсөн тохиолдолд 12 т-оос хэтрэхгүй байх,
- автоугсрааны зөвшөөрөгдөх бүх жин 115 т-оос хэтрэхгүй байх,
- нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн тоормосны идэвхжил доод тал нь 30 % байх,
- тэнхлэг бүр нумтай байх,
- нэг болон хэд хэдэн тэнхлэгт ноогдох ачаалал 10 т-оос хэтэрвэл хийн нумтай байх.

14.4 Бусад тохиолдолд ачаа бүхий нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн зөвшөөрөгдөх дээд хурд 15 км/цаг байна. Тоормосны идэвхжил доод тал нь 18 % байна.

14.5 Ачаагүй нам аралтай чиргүүл, хагас чиргүүл нь ердийн чиргүүл, хагас чиргүүлийн жин хэмжээнд тавих шаардлагуудыг хангасан тохиолдолд зөвшөөрөгдөх дээд хурд нь 70 км/цаг байна. Шаардлага хангасан нөхцөлд ачаа бүхий нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн зөвшөөрөгдөх дээд хурд 60 км/цаг ба бусад тохиолдолд 45 км/цаг байна.

14.6 Ачааны автомашины хөтлөгдөх тэнхлэгийн ачаалал автоугсрааны зөвшөөрөгдөх бүх жингийн доод тал нь 20 %-тай тэнцүү байна.

14.7 Холбоос

14.7.1 Холбоос нь 8.4.1 ба 8.4.2-д заасан шаардлагуудыг хангасан байна.

14.8 Тоормос

14.8.1 Нам аралтай чиргүүл, хагас чиргүүл нь бүрэн, найдвартай ажиллагаа бүхий тоормосны нэг системтэй байна.

14.8.2 Нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийг зүтгүүрээс салгасан тохиолдолд тоормос идэвхжих ёстой.

14.8.3 Зүтгүүр ба нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн холбоос эвдэрсэн тохиолдолд нам аралтай чиргүүл, хагас чиргүүл автоматаар тоормослох боломжтой байна.

14.8.4 Нам аралтай чиргүүл, хагас чиргүүл гар болон ажлын тоормостой байна.

14.8.5 Хөл тоормосны идэвхжил нь нам аралтай чиргүүл нь зүтгүүр автомашиныг татах, эсвэл мөргөхөөс зайлсхийх үүднээс зүтгүүр автомашины тоормосны идэвхжилтэй тохирч байх ёстой.

14.9 Цахилгаан тоноглол

14.9.1 Нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн урд талынхаас бусад талууд ньгэрэлтүүлэх болон дохиоллын хэрэгслээр тоноггосон байна.

14.9.2 Хэрэв нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн өргөн тээврийн хэрэгслийн өргөнөөс 10 см-ээс хэтэрч байвал газрын гадаргуугаас 1 м-ийн өндөрт оврын гэрэлтэй байна.

14.10 Арал

Нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн арал нь ердийн чиргүүл, хагас чиргүүлд тавих шаардлагыг хангасан байна.

14.11 Их бие

Нам аралтай чиргүүл, хагас чиргүүл нь ердийн чиргүүл, хагас чиргүүлд тавих шаардлагыг хангасан байна.

ТӨГСӨВ.